



ТӨВ АЙМАГ  
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/01

Баянтөхөм

Засаг даргын Тамгын газрын бүтэц,  
орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаар тогтоох тухай” 13 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 267 дугаар тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол, 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Б/02 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн бүтцийг дор дурьдсанаар баталсугай.

Санхүү алба (Дарга-1, Төрийн сангийн мэргэжилтэн-1, нягтлан бодогч-2)

Хөдөө аж ахуйн тасаг (Мэргэжилтэн-3)

Хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн-1

Нийгмийн бодлогын мэргэжилтэн-1

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн-1

Архив бичиг хэргийн эрхлэгч-1

Цахим үйлчилгээний ажилтан-1

Нярав-1

Жолооч-1

Гэрээт ажилтан-4

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2021 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОТГОНХИШИГТ



412309003